



2024 ОН IV УЛИРЛЫН ТАЙЛАН

MSE:MLG

www.mlholding.mn



ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол улсын Тээврийн салбарын орлого

↗ **7 их наяд**

Монложистикс Групп Борлуулалтын орлогын өсөлт

↗ **+41%**

Монложистикс Групп Цэвэр ашгийн өсөлт

↗ **+21%**

Монложистикс Групп Импортын ачаа тээврийн өсөлт

↗ **+25%**



КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 10 охин компани, 210 орчим ажилтан, 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчэй Монгол Улсын тээврийн салбарын тэргүүлэгч байгууллага болсон байна.

Монложистикс Групп нь Монгол Улсын иргэдийн өдөр тутам хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлоохос эхлэн уул уурхайн түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг зэрэг тээвэр ложистикийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцсэн тээврийн цогц үйлчилгээг үзүүлсээр байна.

Монложистикс Холдинг ХК нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч Группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдгээрт Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, бизнес хөгжил, Ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

Эрхэм зорилго

Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд

Алсын хараа

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

Үнэт зүйлс

Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанийд тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгуй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтэл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.

Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.

Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээр багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.

ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн
нэгдсэн холбоонд албан
ёсны гишүүнээр элсэв.

Монгол улсын Гаалийн
ерөнхий газраас Гаалийн
зуучлагчийн тусгай
зөвшөөрлийг авав.

Олон улсын тээвэр
зуучийн нэгдсэн
холбоонд албан ёсны
гишүүнээр элсэв.

Rebranding
“Upgrade 10” төслийг
амжилттай эхлүүлэв.

2006 ОН

2010 ОН

2014 ОН

2016 ОН

2005 ОН

2009 ОН

2011 ОН

2015 ОН

2017 ОН

Монлогистикс Ворлдвайд ХХК
анхын ууган компани
байгуулагдав.

Төмөр замын аюулгүй
ажиллагааны тусгай
зөвшөөрлийг хүлээн авав.

Монголын гаалийн
зуучлагчдын
нэгдсэн холбооны
гишүүнээр элсэв.

ISO 9001:2008 Олон улсын
чанарын удирдлагын
тогтолцоог нэвтрүүлэв.

Бүх тээврийг даатгалд
хамруулах үйлчилгээг
нэвтрүүлэв.





Монложистикс Транзит
XXX байгуулагдав.



Портфолио өргөжилт хийж,
3 охин компания байгуулав.



Монложистикс Холдинг
XXX Олон нийтэд
нээлттэй компани
болов.



Төв азийн зам XXX-ийн
51%-ийг өөртөө нэгтгэлээ.

Тяньжин РТЛ XXX-ийг
үүсгэн байгуулав.

2019 ОН

2021 ОН

2023 ОН

2024 ОН



2018 ОН

Оюутолгой компанийн
албан ёсны тээврийн
компаниар шалгарав.



2020 ОН

Монложистикс Холдинг XXX
Толгой компани байгуулагдав.



2022 ОН

Түүхий эдийн экспортын
тээврийг эхлүүлж,
Kaus Australis XXX-ийг
байгуулав.




2023 ОН

Do good HUB ТББ-ыг байгуулав.



ГРУППИЙН БҮТЭЦ



*Тяньжин РТЛ ХХК-ийг шинээр үүсгэн байгуулж, 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр гэрчилгээг нь гардан авав.



ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

ОНЦЛОХ ТЭЭВЭР



Монлогистикс Ворлдвайд ХХК 2024 оны 11-р сараас эхлэн Монгол Улсын Засгийн Газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд байгуулсан Компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотын ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн ачааг тээвэрлэж эхэллээ.



Монлогистикс Ворлдвайд ХХК 2024 оны 11-р сард Тесо Группийн охин компани болох Айсмарк ХХК-ийн зайрмагийн үйлдвэрийн шинэ тоног төхөөрөмжүүдийг амжилттай тээвэрлэж гүйцэтгэлээ.



Монлогистикс Ворлдвайд ХХК нь Монгол Улсын Засгийн Газрын захиалгат найман чингэлэг бүхий арван зургаан авто машиныг АНЭУ-ын Дубай хотоос Улаанбаатар хот руу амжилттай тээвэрлэн авчирлаа.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



1. Монложистикс Групп хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийж, эхний ээлжийн вагонуудаа амжилттай хүлээн авлаа.

Монложистикс Групп нь бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, ерсeldөөний давуу талуудыг бий болгох зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийх IPO-н төлөвлөгөөний дагуу ОХУ-аас худалдан авсан эхний ээлжийн вагонуудаа 2024 оны 12-р сард амжилттай хүлээн авсан бөгөөд 2025 оны 1-р улиралд дараагийн ээлжийн 40 ширхэг вагоныг хүлээн авахад бэлэн болоод байна.

Өөрийн хөдлөх бүрэлдэхүүнтэй болсноор Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтэд оролцох, Монложистикс группийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.



2. Монложистикс Групп ISO 9001:2015 гэрчилгээгээ гардан авлаа.

Монложистикс Групп 2024 оны стратегийн зорилтын хүрээнд үйлчилгээний чанаарын соёлыг нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж, ISO 9001:2015 олон улсын чанаарын удирдлагын тогтолцоог группийн хэмжээнд нэвтрүүллээ.

2024 оны 11-р сарын 20-нд группийн бүрэлдэхүүнд багтдаг нийт зургаан компани олон улсын баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдаж, үл тохиролгүй, зөрүүгүй үнэлгээтэйгээр тэнцсэн. Улмаар 2024 оны 12-р сарын 9-нд Австралийн TQCS International PTY LTD компаниас ISO 9001:2015 чанаарын удирдлагын тогтолцооны гэрчилгээг албан ёсоор гардан авлаа.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



3. Монлогистикс Групп “Тээвэр Ложистикийн Энтрпренер” шагналыг хоёр дахь удаагаа хүртлээ.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас уламжлал болгон зохион байгуулдаг оны шилдэг аж ахуйн нэгж, салбарын шилдгүүдийг шалгаруулдаг “Энтрпренер 2024”-ийн “Тээвэр ложистикийн Энтрпренер” шагналыг Монлогистикс групп 2 дахь удаагаа хүртэж, салбartaа манлайлагч, шилдэг энтрпренер байгууллага болохоо дахин баталлаа.



4. Монлогистикс Групп агаарын тээврийн салбарт үйл ажиллагаагаа өргөжүүллээ.

Монлогистикс Экспресс ХХК нь агаарын тээврийн үйлчилгээг шуурхай, найдвартай үзүүлэх зорилгоор B2B болон B2C сегментэд чиглэсэн олон улсын агаарын тээврийн зуучлал, олон улсын буухиа шуудангийн үйлчилгээг 2024 оны 8-р сараас эхлүүлээд байна.

Гадаад худалдаа, цахим худалдааны эрчимтэй есөлтийг дэмжиж, үйлчилгээгээ илүү өргөн боломж, хялбар шийдлүүдийг санал болгохын төлөө Монлогистикс Экспресс ХХК нь агаарын тээврийн сүлжээг өргөжүүлж, олон улсын зах зээлд өрсөлдөхүйц ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэхээр зорин ажиллаж байна.




—

Үйл ажиллагааны тайлан

- Тээврийн салбарын нийт орлого
- Монлогистикс Группийн орлого
- Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- Монлогистикс Группийн ачааны хэмжээ

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО 297 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЧ ӨМНӨ ЖИЛЭЭС 41.2% ӨСЛӨӨ.


МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО /ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР/



2024 оны 4-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7% өссөн байна.


“Эх сурвалж : YCX ийн мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно.”

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/




2024 оны 4-р улирлын байдлаар Монложистикс Группийн орлого 297 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 41.2% өссөн байна.

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / мянган тонноор /



2024 оны 4-р улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн эргэлийн хэмжээ 128.8 сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 21% өссөн байна.



МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / мянган тонноор /



Монлогистикс группийн ачаа эргэлт 1.1 сая.тн хүрч өмнөх оны мөн үеэс 8% өссөн үзүүлэлттэй байна.


ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ


/ МЯНГАН ТОННООР /



ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ


/ МЯНГАН ТОННООР /

МОНГОЛ УЛС



Монгол улсаар дамжин өнгөрдөг транзит ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 3% өсөж 5 сая.тн хүрсэн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП




Монлогистикс группийн зохион байгуулдаг транзит ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 7.8% өсөж 828 мян.тн хүрсэн байна.

ОЛОН УЛС ДАХЬ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /

МОНЛОЖИСТИКС ГРУПП



Монлогистикс группийн нь гадаад улс доторх ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 71.4% буурч 5 мян.тн хүрсэн байна.



monlogistics
HOLDING

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Нэгтгэсэн санхүү байдлын тайлан
- Нэгтгэсэн орлогын тайлан

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2022 Q4	2023 Q4	2024 Q4
Борлуулалтын орлого	136,095	210,361	296,292
Борлуулалтын өртөг	(119,548)	(192,253)	(272,366)
Нийт ашиг	16,547	18,108	23,926
Борлуулалт, Удирдлагын зардал	(6,244)	(8,482)	(11,154)
Бусад орлого (зардал)	1,116	(336)	(245)
Үйл ажиллагааны цэвэр ашиг	11,419	9,290	12,527
Санхүүгийн орлого (зардал)	(385)	295	(628)
Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)	11,034	9,585	11,899
ОАТ-н зардал	(1,642)	(1,222)	(1,578)
Цэвэр ашиг	9,392	8,363	10,321
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	8,028	5,925	7,463
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,364	2,438	2,858
Бүх дэлгэрэнгүй орлого	9,253	8,301	10,004
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(138)	(62)	(104)
Бусад олз (гарз)			(212)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	9,253	8,301	10,004
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	7,890	5,863	7,147
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,364	2,438	2,858
Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг (алдагдал)	20.28	14.97	18.85

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2022 Q4	2023 Q4	2024 Q4
Мөнгөн хөрөнгө	14,198	22,122	8,710
Дансны авлагы	19,504	22,535	39,584
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	2,461	1,381
Урьдчилж төлсөн төлбөр	103	135	8,585
Бараа материал	5,662	6,050	21,175
Бусад эргэлтийн хөрөнгө	258	1,274	1,773
Эргэлтийн хөрөнгө	39,725	54,577	81,208
Үндсэн хөрөнгө	1,449	1,526	5,467
Ашиглах эрх бухий хөрөнгө	-	857	591
Бусад эргэлтийн бус хөрөнгө	923	648	1,265
Гудвилл			3,463
Эргэлтийн бус хөрөнгө	2,372	3,031	10,785
Нийт хөрөнгө	42,097	57,609	91,993
Дансны өглөг	14,591	12,409	20,791
Урьдчилж орсон орлого	1,558	837	8,001
Богино хугацаат зээл	-	17	7,322
Бусад өглөг	597	465	399
Богино хугацаат өр төлбөр	16,746	13,728	36,514
Үрт хугацаат өр төлбөр	212	442	6,946
Нийт өр төлбөр	16,959	14,169	43,459
Эздийн өмч	23,138	39,285	42,359
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	2,001	4,154	6,175
Нийт Эздийн өмч	25,138	43,439	48,534
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	42,097	57,609	91,993

*Аудитлагдаагүй тайлан



МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК

НОГДОЛ АШИГ ТАРААНА

цэвэр ашгийн

21.9%

нийт

2,137,637,638.80₮

нэгж хувьцаанд

5.40₮

ногдол ашиг
тараах өдөр

2025.04.30

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 07 -ны өдрийн № 25/ТҮЗ/09 тоот тогтоолоор компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 21.9% хувийг буюу нийт 2,137,637,638.80 (хаёр тэрбум нэг зуун гучин долоон сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун гучин найман төгрөг наян мөнгө) төгрөгийг, нэгж хувьцаанд 5.40 (таван төгрөг дөчин мөнгө) төгрөгөөр тооцож, нийт хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг олгохоор шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтооно.

Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд 2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр олгохоор шийдвэрлэлээ.



НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛЭЭС ХУВЬЦАА

ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ НӨХЦӨЛ

Эргүүлэн худалдааж авах
хувьцааны нийт тоо, ширхэг

4,800,000
ширхээс ихгүй

Эргүүлэн худалдан авах
закхиалгын дээд үнэ

210₮

Эргүүлэн худалдан авах
хувьцааны нийт дун

1,008,000,000₮

Эргүүлэн худалдан
авах хугацаа

2025.04.01
2025.12.31

НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛЭЭС ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВНА

“Монлогистикс Холдинг” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн 25/ТУЗ/10 тоот тогтоолын дагуу олон нийтэд санал болгож гаргасанхувьцааныхаа хөрвөхчадварыг нэмэгдүүлэхзорилгоор тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэлээ.

Нийт 4,800,000 ихгүй, ширхэг хувьцааг нэг бүрийг нь 210 төгрөг хүртэл үнээр тооцон, нийт 1,008,000,000 төгрөг хүртэл үнийн дүнгээр хувьцааг худалдан авах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хувьцааны эргүүлэн худалдан авалт нь 2025.04.01 - 2025.12.31 өдрийг хүртэл 8 сарын хугацаатай үргэлжилнэ.



ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

info@mlholding.mn

www.mlholding.mn